



**УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ**

2016 оны 12 сарын 21 өдөр

Дугаар A/175


Улаанбаатар хот

**Бодис, давсны нөөц бүрдүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухайн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар бүлгийн 2.4.1 дэх заалт, 2016 оны А/905 дугаар захирамж, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9, 4 дүгээр хэсгийн 4.4.15 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цас, мөс хайлуулах зориулалтын давс, бодисны зарцуулалт ихсэж өвөлжилтийн байдал хүндэрч болзошгүй байгаа тул нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор шийдвэрлэгдсэн хөрөнгийн хүрээнд 400 тонн давс, 300 тонн цас, мөс хайлуулах зориулалтын бодисыг холбогдох хууль, журмын дагуу шууд худалдан авалт хийх ажлыг шуурхай зохион байгуулахыг Тохжилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр/-т даалгасугай.

2. Цас, мөс хайлуулах зориулалтын бодис худалдан авах ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, холбогдох шийдвэрийн дагуу санхүүжүүлэхийг ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д даалгасугай.

ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД  
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



1110300751